



**Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын төлөөлөгч
Н.Сайхантуяагийн хагас жилд хийсэн ажилын тайлан**

2024.01.01-2024.03.01-ны өдрийг хүртэл Орхон аймгийн нийгмийн даатгалын газрын фэйсбүүк фэйж хуудасны чатбот хариуцан ажилласан ба нийт 1004 иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын 12 төрлийн үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүнээс:

№	Нийгмийн даатгалын иргэдэд үзүүлсэн үйлчилгээ	Үйлчилгээ авсан иргэдийн тоо
1	Тэтгэвэртэй холбоотой зөвлөгөө мэдээлэл	42
2	Тэтгэврийн банк солих	0
3	Тэтгэврийн жил нэмэх	
4	Ажилгүйдлийн тэтгэмжийн зөвлөгөө мэдээлэл	89
5	Жирэмсэн амаржсаны тэтгэмж зөвлөгөө мэдээлэл	132
6	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн зөвлөгөө	118
7	Оршуулгын тэтгэмжийн материал хүлээн авах	0
8	Эрүүл мэндийн даатгалын зөвлөгөө мэдээлэл	231
9	СДД -н гэрээ байгуулах	12
10	СДД-ын гэрээний сунгалт	21
11	СДД -н зөвлөгөө өгөх	959
12	Өргөдөл хүлээн авах	21

Цахимаар нийт 21 баримт бичиг ирсэн. Үүнээс:

1. Тэтгэврийн даатгалтай холбоотой- 6
2. Тэтгэмжийн даатгалтай холбоотой- 2
3. ЭМД,СДД залруулгатай холбоотой – 3
4. Иргэний үнэмлэх болон бусад баримт бичиг-10

2024.03.01-2024.06.03-ны өдрийг хүртэл Орхон аймгийн нийгмийн даатгалын газрын Үйлчилгээний хэсэгт ажилласан. Нийт 2000 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан.

№	Иргэдэд үзүүлсэн үйлчилгээ	Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо
1	Тэтгэврийн материал хүлээн авах	62
2	Тэтгэврийн банк солих	69
3	Тэтгэврийн нэмэгдэл	32
4	Тэтгэврийн сунгалт	6
5	Тэтгэвэртэй холбоотой өргөдөл	21
6	Ажилгүйдлийн тэтгэмжийн материал хүлээн авах	55
7	Оршуулгын тэтгэмжийн материал хүлээн авах	
8	Сайн дурын даатгалын гэрээ байгуулах	116



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

9	Сайн дурын даатгалын гэрээ сунгах	123
10	Эрх үүссэн тодорхойлолт	
11	Эрх үүсээгүй тодорхойлолт	17
12	Эрүүл мэндийн даатгалын зөвлөгөө мэдээлэл	200
13	НДШ тайлан хүлээн авах, баталгаажуулах	216
14	Иргэдэд өгсөн зөвлөгөө мэдээлэл	

2024.01.26-ны өдөр аймгийн засаг даргын А/100 , Улсын Онцгой комиссын 2023 оны 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Мал аж ахуйн өвөлжилт , цаг үеийн ажлыг ” танилцуулан малчдын санал хүсэлтийг сонсож , мэдээ мэдээлэл , судалгаа авч ажиллав. 2024 оны 01 дүгээр сарын 24 , 25-ны өдөрүүдэд Хойд булаг , Дуулагт, Шувуут , Дулааны энгэр , Хонгор морьт , Бригад , Айргын хөндий , Ихрийн бууц , зэрэг газруудаар Баян-Өндөр сумын малын эмч Ц.Энхболд , хүний их эмч Х.Нарантуяа, нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нийт 23 малчин айл өрхөөр биечлэн очих төлөвлөгөөтэйгээр ажиллаа. Нийт 41 малчин иргэнд Нийгмийн даатгалын тухай шинэчлэгдсэн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,тэтгэмжийн тухай хууль, малчны тэтгэврийн тухай, 0-3 настай ээжийн сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалын тухай мэдээллийг хүргэн тэдний шимтгэл төлж ажилласан жилийн тооцож нийгмийн даатгалын шинэчлэгдсэн хуулийн мэдээлэл зөвлөгөө хүргэн ажиллаа.


Уулзалтын тоон мэдээлэл:

№	Зохион байгуулагдсан ажил		Тоо
1.	Нийт орсон өрхийн тоо		23
2.	Зөвлөгөө авсан иргэдийн тоо		41
	Эзэнгүй айлын тоо		4
	Үүнээс	Сайн дурын даатгалын шимтгэл төлдөг даатгуулагчийн тоо	9
		Ажил олгогчоос төлөгддөг	0
		Нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй иргэн	18



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

	Тэтгэвэрт гарсан иргэн	10
	Хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн(групп)	1
3.	Тараасан сурталчилгааны материалын тоо	0
4.	Явсан км	240



2024.05.16-ны өдөр Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газраас Төрийн үйлчилгээг иргэн бүрд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай, чанартай хүргэх зорилгын хүрээнд зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцлоо. Тус өдөрлөгт Нийгмийн даатгалын газрын ахлах төлөөлөгч Н.Шүрэн-Эрдэнэтэй хамт “Нийгмийн даатгалын багц хууль болон 2024 оны шинэчлэгдсэн хууль” цахим үйлчилгээний талаар иргэд, даатгуулагчидад зөвлөгөө мэдээлэл хүргэн ажиллав.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн тушаалаар шинээр байгуулагдсан “Эцэг эхийн зөвлөл”-ийн баг бүрэлдэхүүнд гишүүнээр ажиллаж байна.

Тайлан бичсэн: *Н. Сайхантуяа* /Н.Сайхантуяа/